



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 4/609

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны
стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүй, зохион байгуулалтаар ханган ажиллахыг тус яамны бүх газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.
3. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтийг 2 жил тутамд нэгтгэхийг Бодлого төлөвлөлтийн газар /Б.Буянтогтох/-т, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т тус тус даалгасугай.

САЙД  С.ЭНХБОЛД



141223032

Эрүүл мэндийн сайдын
2022 оны 12 дугаар сарын 15 -ны
өдрийн 4/605 дугаар тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2022-2025 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөөг баталсан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч,
Эрүүл мэндийн сайд

(албан тушаал)


С.ЭНХБОЛД

(гарын үсэг)

2022. 12. 15

(огноо)

Төлөвлөгөөг боловсруулсан:

Эрүүл мэндийн яамны төрийн
нарийн бичгийн дарга

(албан тушаал)


Ц.ЭРДЭМБИЛЭГ

(гарын үсэг)

2022. 12. 15

(огноо)

2022 он
Улаанбаатар хот

1000

1000

1000

1000

Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний бүтэц, агуулга

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл	3-4
Бүлэг 2. Мандатын шинжилгээ	4-5
Бүлэг 3. Алсын хараа	5
Бүлэг 4. Эрхэм зорилго	5-6
Бүлэг 5. Орчны шинжилгээ	6-9
Бүлэг 6. Стратегийн зорилго	9
Бүлэг 7. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж байгууллагын бүтцийн уялдаа зураглал	9
Бүлэг 8. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги	10-21
Бүлэг 9. Хавсралт	21-38

Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс 1990 оноос хойш эмнэлэгт суурилсан тогтолцооноос илүү үр дүнтэй, үйлчлүүлэгч төвтэй загварт шилжүүлэх зорилготой хэд хэдэн шинэчлэлийг хэрэгжүүлсээр ирсэн.

Шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбар хэд хэдэн бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөөг үндэсний болон салбарын түвшинд боловсруулан салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж ирсэн. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 1999 оны 46 дугаар тогтоол "Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого";
- Монгол Улсын Их Хурлын 2001 оны 81 дүгээр тогтоол "Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого";
- Монгол Улсын Их Хурлын 2004 оны 21 дүгээр тогтоол "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого";
- Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 72 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө (2006-2015);
- Монгол Улсын Их Хурлын 2007 оны 45 дугаар тогтоол "Монгол улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого";
- Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоол "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого";
- Эрүүл мэндийн сайдын 2013 оны 176 дугаар тушаал "Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого";
- Монгол Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тоот тогтоол "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого";
- Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого".

Түүнчлэн сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хүн амын эрүүл мэндэд тулгамдаж буй асуудлаар нийт 44 үндэсний хөтөлбөр, стратегийг Засгийн газрын тогтоол (14) болон Эрүүл мэндийн сайдын тушаалаар (19), яамд хоорондын хамтарсан тушаалаар (1) 4-10 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж ирсэн.

Дээрх төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж ирснээр манай улс Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд дэвшүүлсэн эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилтдоо амжилттай хүрсэн орны нэг болохын зэрэгцээ хүн амын дундаж наслалт 1992 онд 62,7 байсан бол 2021 онд 71.0 болж уртассан байна.

Гэсэн хэдий ч салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан бодлогын баримт бичиг нь тухайн үеийн улс төр, Засгийн газар, хүний нөөцийн тогтворгүй байдлаас шалтгаалан бодлогын залгамж холбоо алдагдах, санхүүжилт шийдвэрлэгдэхгүй байх зэргээс шалтгаалан тавьсан зорилгодоо хүрэхэд хүндрэл үүсч хэрэгжилт удааширч байсан.

2020 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу салбарт хэрэгжиж байсан дээрх олон төрлийн бодлогын баримт бичгийг хүчингүй болгон улсын хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үе шат, цагалбарыг баталгаажуулсан.

Өнөөгийн байдлаар салбарын хэмжээнд урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогыг "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэл, Монгол улсын жилийн төлөвлөгөөнд тулгуурлан хэрэгжүүлж байна.

Дээрх хөгжлийн бодлогын баримт бичгийг амжилттай хэрэгжүүлэхэд салбарын хэмжээнд дунд хугацаанд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн төсөв, байгууллагын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6-д Төрийн захиргааны төв байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүргийг заасан ба 9.6.5 дахь заалтад "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх" гэж заасны дагуу Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж байна.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн Газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам болон төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу салбарын чиг үүргийн мандатыг 2019 онд хийсэн. Уг шинжилгээгээр Монгол Улсын үндсэн хууль болон хүн амын эрүүл мэнд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдол бүхий нийт 231 хуульд дүн шинжилгээ хийсэн.

Дүн шинжилгээ хийхдээ эрүүл мэндийн салбарын чиг үүргийг дараахь байдлаар тодорхойлсон байна.



Чиг үүргийн дахин хуваарилах аргачлалын дагуу хийгдсэн дүн шинжилгээг үндэслэн салбарт мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчны хүрээнд мандатын шинжилгээг дараах байдлаар хийв.

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		231
Үүнээс:	Тухайн салбарын хэмжээнд шууд хамаарах хуулийн тоо	12

	Нийтлэг мөрдөж байгаа хуулийн тоо (бусад холбогдох хуулийн тоо)	219
Ерөнхий чиг үүрэг: Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүргийн оролцогчид
ҮЧҮ-1 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ (322/3349)	1. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагаа (183/2120)	БОАЖЯ, СЯ, ХНХЯ, БШУЯ, ХХААХҮЯ, МХЕГ, Аймаг, дүүргийн Засаг дарга нар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, бүх шатны боловсролын байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, аж ахуйн нэгж байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэд
	2. Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг тандах үйл ажиллагаа (49/408)	
	3. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа (42/409)	
	4. Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа (48/412)	
ҮЧҮ-2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ (79/2856)	5. Эмчлэх тусламж, үйлчилгээ (24/1286)	ХНХЯ, БХЯ, ХЗДХЯ, СЯ, Харьяа агентлаг, Аймаг, нийслэлийн ЭМГ, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод
	6. Сэргээн засах тусламж, үйлчилгээ (24/1049)	
	7. Хөнгөвчлөх, асаргаа сувилгааны тусламж, үйлчилгээ (8/201)	
	8. Яаралтай тусламж, үйлчилгээ (23/20)	
ҮЧҮ-3 Эм зүйн тусламж, үйлчилгээ (139/2073)	9. Эмийн зохицуулалт, чанар, аюулгүй байдал (72/943)	ХХААХҮЯ, СЯ, ХЗДХЯ, ЗТХЯ, МХЕГ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эм ханган нийлүүлэх байгууллагууд, Эмийн үйлдвэр, Төрийн болон хувийн хэвшлийн бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага, эм ханган нийлүүлэх байгууллагууд, Гадаад улсын эмийн үйлдвэрийн төлөөлөгчийн газар, мэргэжлийн холбоо, нийгэмлэг, төрийн бус байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл,
	10. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж үйлдвэрлэл, эрүүл мэндийн технологи (38/474)	
	11. Эмийн зохистой хэрэглээ (29/656)	

Эрүүл мэндийн салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх журмын нийт 69 захиргааны хэм хэмжээний акт (Сайдын тушаал) хэрэгжиж байгаагийн 36 нь бусад яамд (ХНХЯ, ХЗДХЯ, СЯ, БХБЯ, ХХААХҮЯ, БСШУЯ, БОАЖЯ) - тай хамтран баталсан 33, Эрүүл мэндийн сайд дангаар баталсан 36 тушаал байна.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Дэлхийн жишигт хүрсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн бүрт

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл дадал хэвшилтэй, идэвхитэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж,

байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж монгол хүний эрүүл дундаж наслалтыг уртасган 2024 онд 73-д хүргэнэ.

Зорилгын хүрээнд Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичигт дараах зорилтыг дэвшүүлэн тавьсан.



ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугцааны бодлогын баримт бичигт тавьсан зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлыг төлөвлөлтийн баримт бичигт үе шаттайгаар тусган хэрэгжүүлэх зорилгоор салбарын өнөөгийн нөхцөл байдалд дотоод, гадаад орчны давуу болон сул талыг тодорхойлсон ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ хийв.

Нэг. ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
1. Бүтэц, зохион байгуулалт	
- Монгол Улсын нутаг дэвсгэрийн нэгж аймаг, сум бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүтэц, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоотой - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг баталгаажуулсан стандарттай - Тусламж үйлчилгээг аймгуудын хувьд бүсчлэн үзүүлэх БОЭТ-үүд байгуулагдсан - Тусламж үйлчилгээг анхан болон лавлагаа шатлалын хэлбэрээр үзүүлэх тогтолцоо бүрэлдсэн	- Зарим сумд аймгийн төвөөс хэт ойр зарим нь алслагдсан байдалтай оршдог - Стандарт нь сумын эрүүл мэндийн төвд бүрэн хэрэгжих боломж хязгаарлагдмал - БОЭТ-д харьяа бусад аймгаас ирж үйлчлүүлж байгаа иргэдийн тоо маш бага - Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын байршил УБ хотын алслагдсан дүүрэгт оновчтой бус
2. Хүний нөөц	
- Салбарын хүний нөөц бэлтгэх тогтолцоо бүрэлдсэн 10000 хүн амд ногдох их эмчийн (38.5) тоогоор дэлхийн (16.4) болон бүсийн (39.5) дундажаас өндөр 10000 хүн амд ногдох сувилагчийн (42.1) тоогоор дэлхийн (39.5) болон бүсийн (39.5) дундажаас өндөр	- Эмнэгийн мэргэжилтэн бэлтгэн гаргаж байгаа сургуулиудын чанар жигд бус - Их эмчийн тоо хангалттай хэдий ч хөдөө орон нутагт их эмч дутагдалтай - Зарим төрлийн нарийн мэргэшлийн эмч үндэсний хэмжээнд дутагдалтай цөөн бэлтгэгдсэн - Их эмчтэй харьцуулахад сувилагчийн тоо цөөн, нарийн мэргэшсэн сувилагч нар хангалттай бус

• Эрүүл мэндийн ажилтны ажил мэргэшлийн индекс баталгаажсан • Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг баталгаажуулсан • Эрүүл мэндийн ажилтанг анхан шат болон орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах зорилго бүхий тэтгэвэр тэтгэмжийн асуудлаарх эрх зүйн орчин хуулиар баталгаажсан	• Ажил мэргэшлийн индекс хэт төрөлжсөн • Орон нутагт ажиллах эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай • Орон нутагт ажиллах эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгаа (байр орон сууц) бүрэн хангагдаагүй • Эмч нарыг нарийн мэргэшүүлэх үйл явц тусламж үйчилгээний хэрэгцээ шаардлагатай уялдах уялдаа сул
3. Салбарын санхүүжилт	
• Салбарын санхүүжилтийн шинэчлэл эхэлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нэвтэрч эхэлсэн • Эрүүл мэндийн даатгалын сан ЭМЯ-ны харьяанд шилжин ирсэнтэй холбогдуулан салбарын санхүүжилт нэмэгдсэн • Анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилт 2015 оноос хойш 4 дахин нэмэгдэхийн зэрэгцээ зарим төрлийн тусламж үйлчилгээг ЭМД-ын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн • Алслагдсан орон нутагт тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагад алслагдсан орон нутгийн индекс ашиглаж эхэлсэн • ЭМД-с санхүүжиж байсан тусламж үйлчилгээний нэр төрөл, санхүүжилтийн хувь нэмэгдэж байгаа	• Гүйцэтгэлийн санхүүжилтийн талаар эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, хүний нөөцийн мэдлэг чадвар дутмаг, ойлголт хандлага жигд бус • Эрүүл мэндийн салбарын санхүүжилт ДЭМБ-аас улс орнуудад зөвлөмж болгосон хэмжээнд хүрэхгүй байгаа • Хувь хүний хармаанаас төлөх төлбөрийн хэмжээ ДЭМБ-ын зөвлөсөн хэмжээнээс өндөр хэвээр байна • Салбарын санхүүгийн нөхцөл байдлыг илтгэх Үндэсний тооцооны чадавх бүрэн бүрэлдээгүй • Эрүүл мэндийн эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөц салбарын хэмжээнд хэт цөөн
4. Мэдээлэл технологи	
• Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн нэг хэсэг нь Эрүүл мэндийн салбарын цахим шилжилт болж байгаа • ЭМБ-ууд бүгд интернет ашиглах боломжоор хангагдсан • ЭМБ-ууд цахимаар мэдээлэл, тайлан гаргах программ хангамжтай • ЭМБ-дад мэдээлэл технологийн ажилтан ажиллуулах эрх зүйн орчин бүрдсэн	• Салбарт хэрэглэгдэж байгаа программ хангамжууд хоорондоо хөрвөх боломжгүй нэгдмэл бус, мэдээлэл солилцооны нэгдсэн платформ байхгүй • Програмын хөгжүүлэлт хийх үйл ажиллагаа хувь хүн, компаниас хараат • Мэдээллийн технологийн чиглэлээр хүний нөөц дутмаг • Эрүүл мэндийн ажилтнуудын мэдээллийн технологийн талаарх чадавх сул • Байгууллагуудын компьютер түүний дагалдах хэрэгслийн хүчин чадал хангалтгүй, хуучирсан • Мэдээллийн технологийн ажилтны цалин хөлс бага
4. Салбарын засаглал, ил тод байдал	

• Салбарын хэмжээнд эмнэлгийн хагас бие даасан байдал хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн • Эрүүл мэндийн байгууллагуудад Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн • Салбарын хэмжээнд болон орон нутаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг түвшин бүртээ вебсайт хуудсаар дамжуулан хүргэж байна. • Салбарын хэмжээнд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөвлөл байгуулагдан ажиллаж байна. • Салбарын хэмжээнд зарим үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар гүйцэтгүүлж байгаа	• Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн чадавх дутмаг • Салбарын хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг бодитой үнэлэх тогтолцоо бүрэн бүрэлдээгүй, хөндлөнгийн хяналтын механизм сул • Эмч, эмнэлгийн мэргэжилтний харьцаа хандлага хангалтгүй • Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, цогц арга хэмжээний хэрэгжилт, түүний хэрэгжилтийн үнэлгээ олон нийтэд ил тод бус
Хоёр. ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
1. УИХ, Засгийн газрын түвшинд	
• Улсын хэмжээнд урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлсон бодлогын баримт бичиг батлагдан улс орон даяар хэрэгжиж эхэлсэн • Корона вируст халдвар /КОВИД-19/ цартахлын нөхцөл байдал, сургамжит байдалд үндэслэн эрүүл мэндийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэмжлэг нэмэгдэж байгаа.	• Дэлхийн болон улс орны эдийн засгийн хямралтай холбоотойгоор бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагаа хэрэгжих боломжгүй болох, эрүүл мэндийн салбарын санхүүжилт хөрөнгө оруулалтын хэмжээ буурах
2. Хууль эрх зүйн зохицуулалтын хувьд	
• Хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалах чиглэлээрх хууль эрх зүйн орчин хангалттай бүрэлдсэн	• Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа гол гол хуулиудад ойр ойрхон хугацаанд нэмэлт өөрчлөлт байнга орж байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. • Хуулийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, тогтмол хянах хүний нөөц, чадавх хангалттай бус байгаагаас хууль тогтоомжийн хэрэгжилт сул байна.
3. Улс орны нийгэм, эдийн засгийн үзүүлэлт ¹	
• Дэлхийн тэргүүлэх 2 эдийн засаг (зах зээл)-т ойр байрлал, хоёр хөрштэй найрсаг хамтын ажиллагаа, зах зээл, эдийн засгийн ирээдүйн боломж; • Мэдээлэл технологийн эрчимжилт, цахим шилжилт;	• Засаглал сул, бодлого тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалтын орчныг муутгаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхэх аюултай; • Гадаад өрийн дарамт өндөр; • Уул уурхайгаас хэт хамаарал бүхий эдийн засгийн бүтэцтэй, Экспорт.

¹ Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг товхимол


• Даяаршлын хүрээнд үйлдвэрлэлийн хямд орцуудыг хайсан гадны хөрөнгө оруулалтыг татах боломж өндөр; • Байгалийн цэвэр, органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж экспортлох боломж; • Дэд бүтэц, төмөр зам, тээвэр логиستيкийн төвийн тогтолцоо бүрдүүлж зах зээлийн хараат байдлаас гарах боломж;	импортын хувьд ганц зах зээлээс хараат байдал өндөр; • Олон их дээд сургуультай боловч боловсролын чанар муу; • Хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн хөрс, утаа орчны бохирдол их; • Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар нэмэгдэж байгаа; • Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан нь ихэвчлэн амьдралын хэв маягаас үүдэлтэй харьцангуй сэргийлж болох нас баралт эзэлж нэмэгдэх хандлагатай; • Кибер аюул заналд өртөх, мэдээллийн аюулгүй байдал сул.
---	--

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулан орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхийг бэхжүүлэн гүйцэтгэлийн санхүүжилт, цахим мэдээллийн тогтолцоог бүрэн нэвтрүүлж, эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА ЗУРАГЛАЛ

2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 4 952 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 13, тусгай мэргэжлийн төв 15, бүсийн оношлогоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг 4, нийгмийн эрүүл мэндийн төв 9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сумын эрүүл мэндийн төв 321, өрхийн эрүүл мэндийн төв 208, хувийн ортой эмнэлэг 239, хувийн клиник 1548 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.



НАЙМ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2022-2025 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д.д	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги (арга зам)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2022 он	Зорилтот түвшин 2023 он	Зорилтот түвшин 2024 он	Зорилтот түвшин 2025 он	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүрэг: ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ХАМГААЛАХ								
Үндсэн чиг үүрэг: 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ								
1	Зорилт-1. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оншилгоо шинжилгээнд жил бүр 30-аас доошгүй хувийг хамруулна.	Арга хэмжээ-1. "Эрүүл идэвхитэй амьдрал" нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээлэл бүхий веб хуудас нээн ажиллуулах Арга хэмжээ-2. Бүх шатны боловсролын байгууллагад эрүүл мэндийн хичээл заах багш нарт зориулсан цахим хичээлийн контент, заах аргачлал боловсруулж Боловсролын салбарын цахим платформд байршуулах	Веб хуудсаар бэлтгэн түгээсэн сэдэвчилсэн мэдээллийн багцын тоо	-	15	25	36	Улсын төсөв, Эрүүл мэндийг дэмжих сан, Олон улсын төсөл, хөтөлбөр
2			Цахим платформд байршуулсан контентийн тоо	-	5	8	10	Эрүүл мэндийг дэмжих сан Олон улсын төсөл хөтөлбөр
3		Арга хэмжээ-3. Өвчний хяналт сэргийлэлтийн төв байгуулах	Төв байгуулах үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	40	50	70	100	Улсын төсөв
4		Арга хэмжээ-4. "Эрүүл, идэвхтэй амьдрал 2021-2024 оны төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	38.4	60	100	-	Улсын төсөв, ЭМД-ын сан, Олон улсын

5	Арга хэмжээ-5. "Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	40	70	100	-	төсөл хөтөлбөр
6	Арга хэмжээ-6. "Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	40	70	100	-	төсөл хөтөлбөр
7	Арга хэмжээ-7. "Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	40	70	100	-	
8	Арга хэмжээ-8. "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	48.6	70	100	-	
9	Арга хэмжээ-9. Хүн амын дунд эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо зохион байгуулах	Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь	12	60	70	80	
10	Арга хэмжээ-10. Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг бүх аймаг, дүүрэгт байгуулах	Байгуулагдсан Эрүүл мэндийг дэмжих төвийн тоо	27	-	32	36	Улсын төсөв Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр
11	Арга хэмжээ-11. "Орчны эрүүл мэнд хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	30	70	100	-	Улсын төсөв, Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр
12	Арга хэмжээ-12. Хүн амын хоол тэжээлийн VI судалгаа үндэсний түвшинд зохион байгуулах	Судалгааны ажлын явцын хэрэгжилтийн хувь	40	100	-	-	

13	Арга хэмжээ-13. Тамхины тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	80	100	-	Улсын төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр
14	Арга хэмжээ-1. "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	20	50	80	Улсын төсөв, ЭМД-ын сан, Олон улсын төсөл хөтөлбөр
15	Зорилт-2. Халдварт өвчнөөс сэргийлэх хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд бэхжүүлж нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлж зонхилон тохиолдох халдварт сүрьеэгийн шалтгаант нас баралтыг 2021 онтой харьцуулахад 1,5 дахин бууруулна.	Арга хэмжээ-2. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлэх	-	30	70	Улсын төсөв, ЭМД-ын сан, Олон улсын төсөл хөтөлбөр
16		Арга хэмжээ-3. Аймаг дүүрэгт Шуурхай удирдлагын нэгж байгуулах	4	17	21	Улсын төсөв
17		Арга хэмжээ-4. Хилийн боомтуудад тандалтын нэгж байгуулах	-	4	8	Улсын төсөв
18		Арга хэмжээ-5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эм, эмнэлгийн хэрэгслийн тасралтгүй байдлыг хангах зорилгоор Улсын төсөвт үйлдвэрийн газар (Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн төв) байгуулах	60	100	-	Улсын төсөв
19		Арга хэмжээ-6. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	90	100	-	Улсын төсөв

20	Арга хэмжээ-7. Товлолт дархлаажуулалтад хүний папилома вирусийн эсрэг вакцин нэвтрүүлэх	Хүний папилома вирусийн дархлаажуулалтад хамрагдсан 11 насны хүн амын 33элх хувь	-	75	80	85	Улсын төсөв, Олон улсын байгууллага	
21		Арга хэмжээ-8. Вакцины дархлал тогтоцлын түвшинг үнэлэх, лабораторид суурилсан тандалт, судалгаа хийх	Гүйцэтгэлийн хувь	-	30	60	100	Улсын төсөв, ШУТС, Олон улсын байгууллага
Үндсэн чиг үүрэг: 2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ								
22	Зорилт-3. Оношилгоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэн иргэд орон нутагтаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж орон нутгаас тусламж үйлчилгээ авахаар ирсэн иргэдийн урсгалыг хувиар бууруулсан байна.	Арга хэмжээ-1. Өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлэх	Хувилбарыг туршин нэвтрүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	20	40	80	100	Улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
23	технологийг нэвтрүүлэн иргэд орон нутагтаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж орон нутгаас тусламж үйлчилгээ авахаар ирсэн иргэдийн урсгалыг хувиар бууруулсан байна.	Арга хэмжээ-2. Шаардлагатай дүүрэг, сумдад анхан шатны эрүүл мэндийн байгууллага байгуулах	Шинээр байгуулагдсан анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тоо	-	3	6	9	Улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
24	нутагтаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж орон нутгаас тусламж үйлчилгээ авахаар ирсэн иргэдийн урсгалыг хувиар бууруулсан байна.	Арга хэмжээ-3. Аймаг, дүүргийн эмнэлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж төвлөрлийг сааруулах, орон нутагтаа оноолуулж, эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх	Урлогийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа аймгийн нэгдсэн эмнэлгийн тоо	15	17	19	21	Улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
25	ирсэн иргэдийн урсгалыг хувиар бууруулсан байна.	Арга хэмжээ-4. Уламжлалт анагаах ухааны чиглэлийн эмнэл зүйн заавар боловсруулан үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх	Хавдрын хими эмчилгээ нэвтрүүлсэн аймгийн нэгдсэн эмнэлгийн тоо	-	6	13	21	Улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
26	Уламжлалт анагаах ухааны чиглэлийн эмнэл зүйн заавар боловсруулан үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх	Ундэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан эмнэл зүйн зааврын тоо	0	8	16	20	Улсын төсөв, Олон улсын дэмжлэг	

27	Арга хэмжээ-5. Монгол улсад эмчлэх боломжгүй өвчний технологийг дамжуулах, нутагшуулах	Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчин эмгэг буурсан хувь	- (26)	15.3 (22)	23.0 (20)	30.7 (18)	Улсын төсөв, Олон улсын дэмжлэг
28	Арга хэмжээ-6. Урт хугацааны тусламж, үйлчилгээний үлгэрчилсэн загвар боловсруулах	Үлгэрчилсэн загвар боловсруулах үйл ажиллагааны явцын хувь	30	50	80	100	Улсын төсөв
29	Арга хэмжээ-7. Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулах	Урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ЭМБ-ны тоо	-	3	5	8	Улсын төсөв
30	Арга хэмжээ-8. Зүрх судасны төв байгуулах	Барилга угсралтын ажлын хувь	0	0	10	30	Улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
31	Арга хэмжээ-9. Сүрьеэгийн эмнэлэг байгуулах	Барилга угсралтын ажлын хувь	0	0	10	30	Улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
32	Арга хэмжээ-10. Геронтлогийн үндэсний төв байгуулах	Барилгын угсралтын ажлын хувь	0	30	60	100	Улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
33	Арга хэмжээ-1. Олон улсын жишигт нийцсэн Яаралтай тусламжийн төв байгуулах	Барилгын угсралтын ажлын хувь	46	80	100	-	Улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
34	Зорилт-4. Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхийг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэл хийнэ.	Төв байгуулах ажлын гүйцэтгэлийн хувь	0	30	70	100	АХБ-ны төсөл
35	Арга хэмжээ-2. Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн парк шинэчлэл хийх	Парк шинэчлэл хийгдсэн хувь	33 (66)	60 (120)	85 (170)	100 (200)	Улсын төсөв, Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр

36	Арга хэмжээ-3. Осол гэмтлийн хар цэгүүдэд эмнэлгийн харалтай тусламж үйлчилгээ үзүүлэх нэгж байгуулах	Тусламж үйлчилгээ үзүүлж байгаа нэгжийн тоо	10	20	30	25	Улсын төсөв
37	Арга хэмжээ-4. Эмнэлгийн харалтай болон түргэн тусламжийн чиглэлээр олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх тогтолцоо бүрдүүлэх	Яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээнд ажиллаж байгаа олон нийтийн эрүүл мэндийн ажилтны тоо	-	20	80	140	Олон улсын төсөл, хөтөлбөр

Үндсэн чиг үүрэг: 3. Эм зүйн тусламж, үйлчилгээ

38	Зорилт-5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг 85 хувьд хүргэнэ.	Арга хэмжээ-1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай шинэчилсэн найруулга батлуулж, хэрэгжүүлэх	Хуулийн шинэчилсэн найруулга батлуулах үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	20	80	100	-	Улсын төсөв
39		Арга хэмжээ-2. Уламжлалт эмийн фармакопей боловсруулан хэрэгжүүлэх	Батлагдсан фармакопейн тоо	0	20	40	50	Улсын төсөв
40		Арга хэмжээ-3. Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлэх	Сүлжээнд нэгдэж, тэсвэржсэн нянгийн мэдээлэл гаргаж хэвшсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	-	9	21	46	Улсын төсөв
41		Арга хэмжээ-4. Эмийн хяналтын лабораторийн чадавхийг бэхжүүлэх, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах	Олон улсын стандарт нийцсэн техник тоног төхөөрөмжийн хангалтын хувь	-	30	50	80	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр
42	Арга хэмжээ-5. Үндэсний уламжлалт эмийн үйлдвэрүүдэд "Эм үйлдвэрлэлийн зохистой дадал" нэвтрүүлэх	Уламжлалт эмийн үйлдвэрлэлд "Эм үйлдвэрлэлийн зохистой дадал"	14.2	28.5	42.8	57.1	Улсын төсөв	

			(GMP) нэвтрүүлсэн үйлдвэрийн хувь					
43	Арга хэмжээ-6. Эмийн төвлөрсөн худалдан авалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх	Төвлөрсөн худалдан авалтаар авч байгаа эмийн төрөл	15	-	25	35	Улсын төсөв	
44	Арга хэмжээ-7. Монгол Улсын хүн амын өвчлөл, нас баралттай уялдуулан манай улсад бүртгэлжүүлэх шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн судалгаа хийх	Судалгааны ажлын явцын хэрэгжилтийн хувь	-	50	100	-	Улсын төсөв	
45	Арга хэмжээ-8. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулга, баталгаажилтын лаборатори байгуулах	Лаборатори байгуулах үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50	100	-	Улсын төсөв	
46	Арга хэмжээ-9. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний мэргэшсэн явуулын баг орон нутагт ажиллуулах	Орон нутагт явуулын багийн шалгалт, тохируулга хийсэн тоо	-	1	2	3	Улсын төсөв, орон нутгийн төсөв	
47	Арга хэмжээ-10. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний бүртгэл, хяналтын цахим тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх	Цахим системд нэгдсэн эмийн чанар, аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны төрөл (эмийн бүртгэл, үйлдвэрлэл, нөөц, түгээлт, гаж нөлөө, эмийн үнэ, тусгай зөвшөөрөл, байгууллага, тандалт, чанарын хяналт)	3	6	8	10	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр	
4. Бусад чиг үүрэг								

48		Арга хэмжээ-1. Даатгалын сангийн бие даасан байдлыг хангах зорилгоор орлогын шинэ эх үүсвэрийг бий болгох хэрэгцээний үнэлгээ хийх	Хэрэгцээний үнэлгээ, санхүүжилтийн тооцооллын гүйцэтгэлийн хувь	-	50	100	-	ЭМД-ын сан, Улсын төсөв
49	Зорилт-6. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж, улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг сайжруулж гүйцэтгэлийн санхүүжилтийг туслаж үйлчилгээний бүх төрөлд 100 хувь нэвтрүүлсэн байна.	Арга хэмжээ-2. Төр шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлийн хувь нэмэгдүүлэх (ажил олгогч, ажилтны хувь хэмжээнд хүргэх) Арга хэмжээ-3. Урт хугацааны даатгал нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх нөхцөл байдлын дүн шинжилгээ, актуал тооцоо хийх.	Шимтгэлийн хувь хэмжээ хувиар Эрх зүйн орчин бүрдүүлэх үйл ажиллагааны хэрэгжлтийн хувь	1	2	2	3	Улсын төсөв
50			Эрх зүйн орчин бүрдүүлэх үйл ажиллагааны хэрэгжлтийн хувь	-	50	100	-	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр
51		Арга хэмжээ-4 Эрүүл мэндийн даатгалын сангийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоо бий болгох	Эрүүл мэндийн даатгалын байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нэгдсэн үнэлгээний хувь	85	90	92	95	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр
52		Арга хэмжээ-5. Салбарын шинэчлэлийн хүрээнд нэвтрүүлсэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үр нөлөөний байдалд үнэлгээ хийх	Иргэдийн халааснаас гарах зардлын бууралтын хувь Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хамралтын хувь	34,5	33,5	32,5	31	Улсын төсөв
53	Зорилт-7. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлж, алсын	Арга хэмжээ-1. Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх Арга хэмжээ-2. Дүрс архивлан хадгалах	Цахим платформд нэгдсэн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь Дүрс архивлан хадгалах (PACS)	-	50	80	100	Гадаадын зээл тусламж, Олон улсын төсөл, хөтөлбөр
54				7	10	21	48	Гадаадын зээл

61	Зорилт-9. Эрүүл мэндийн салбарын удирдлага зохион байгуулалт, ил тод байдал, хууль эрх зүйн	Арга хэмжээ-4. Эрүүл мэндийн салбарт олон нийтийн эрүүл мэндийн ажиглан ажиглах эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлэх	Олон нийтийн эрүүл мэндийн ажиглалтын тоо	-	40	70	100	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр
62		Арга хэмжээ-5. Салбарын хүний нөөцийн нэгдсэн сан бүрдүүлэх	Хүний нөөцийн нэгдсэн хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиглалааны хэрэгжилтийн хувь	40	70	100	-	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр
63		Арга хэмжээ-6. Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацийн тэргүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэн гадаад улсад урт хугацааны сургалтад хамруулах	Гадаад улсад урт хугацаагаар сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо	-	6	12	20	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр
64		Арга хэмжээ-7. Эмнэлгийн мэргэжилтний ажиглан суралцах арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хүрээнд ажиглан суралцсан эмч, нэмэгдсэн хувь	- (115)	10 (126)	10 (137)	10 (148)	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр
65		Арга хэмжээ-8. Эрүүл мэндийн ажиглалтын нийгмийн хамгааллыг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	30	50	80	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр
66		Арга хэмжээ-9. Туслах сувилалчийг богино хугацаагаар (3-6 сар) бэлдэх	Туслах сувилалчийн тоо	-	350	700	1050	Улсын төсөв
67		Зорилт-9. Эрүүл мэндийн салбарын удирдлага зохион байгуулалт, ил тод байдал, хууль эрх зүйн	Эрүүл мэндийн багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах үйл	10	40	70	100	Улсын төсөв

	зохицуулалтыг сайжруулж багц хуулиудад холбогдох өөрчлөлт, шинэчлэлтийг тусгасан байна.		ажиллагааны хэрэгжилтийн хувь						
68	Арга хэмжээ-2. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчилгээний хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод нээлттэй болгох	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн нэмэгдсэн хувь	-	10	10	10	Улсын төсөв, ЭМДС, Олон улсын төсөл, хөтөлбөр		
69	Арга хэмжээ-3. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл боловсруулан хэрэгжүүлэх	Тэргүүлэх чиглэлийн хүрээнд хувийн хэвшил, ТББ-аар гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээний нэр төрөл	-	30	70	100	Улсын төсөв, ЭМДС, Олон улсын төсөл, хөтөлбөр		
70	Арга хэмжээ-4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх	Хөндлөнгийн үнэлгээ хийгдэж байгаа тусламж үйлчилгээний төрөл	-	2	2	5-аас доошгүй	Улсын төсөв		

1.1. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХУРАНГУЙ

2016-2020 онд хэрэгжүүлсэн хөгжлийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний үр дүн үр нөлөө

Эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлсэн стратегийн 5 зорилт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт				
			2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	

ҮЧҮ-1 НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ:

Стратегийн зорилтын нэр, дугаар: 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2. Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах, алслагдсан орон нутагт явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Стратегийн зорилтыг хэрэгжүүлснээр гарсан үр дүн: Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг анх удаа эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэн өвчлөл, эндэгдлийн 2 дахь шалтгаан болж байгаа 1684 хорт хавдрын тохиолдлыг эрт үед нь оношилж, эмчилгээнд хамрууллаа. Үзлэгээр 3 хүн тутмын нэг нь таргалалт, чихрийн шижин, артерийн даралт ихсэх өвчтэй байгааг илрүүлэн зүрхний шигдээс, тархины харвалт зэрэг өвчнөөс сэргийлж, хянах боломжийг бүрдүүлэв.

Энэ үйл ажиллагаанд эрүүл мэндийн даатгалын сангаас 10 тэрбум төгрөг зарцуулсан байна. 2019, 2020 онд төсвийг тус тус нэмэгдүүлж, УИХ-аар батлуулсан. Тухайлбал, урьдчилан сэргийлэх үзлэгт 2019 онд 10.1 тэрбум төгрөг зарцуулсан бол энэ онд 13,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 23,9 тэрбум төгрөг болголоо.

1.	Үр дүнгийн шагуур үзүүлэлт №1. Артерийн даралт ихсэх өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтын хувь	59.0	69.1	71.7	77.4	
2.	Үр дүнгийн шагуур үзүүлэлт №2. Чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтын хувь	55.5	65.5	67.8	73.1	
3.	Үр дүнгийн шагуур үзүүлэлт №3. Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтын хувь	44.9	37.4	37.4	38.8	

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны жилийн эцсийн тайлан

Стратегийн зорилтын нэр, дугаар: 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.4.Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үе шаттайгаар 2 дахин нэмэгдүүлнэ. Стратегийн зорилтыг хэрэгжүүлснээр гарсан үр дүн: Монгол Улсын Засгийн газар эрүүл мэндийн салбарын санхүүжилт, төсвийг тогтвортой нэмэгдүүлж, 2016 онд 691,1 тэрбум төгрөг байсныг 2020 онд 964,6 тэрбум төгрөг буюу 40 хувиар нэмэгдүүлсэн. Ингэснээр эрхтэн шилжүүлэн суулгах, диализийн эмчилгээ, дархлаа дарангуйлах, олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмийн санхүүжилтийг төр 100 хувь хариуцдаг болсон. Тухайлбал, диализийн эмчилгээнд нэг хүн сард дунджаар 1.4 сая, жилд 16.6 сая төгрөг зарцуулах шаардлагатай болдог. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд энэхүү эмчилгээнд хамрагдаж байгаа 910 хүн тэдний гэр бүлд нь учрах санхүүгийн дарамтыг төр ийнхүү бууруулж байна.							
1.	Үр дүнгийн шагуур үзүүлэлт №1. Эрүүл мэндийн санхүүжилт, тэрбум төгрөгөөр	Бодит тоо	691.1	695.9	766.3	839.9	964.6

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны жилийн эцсийн тайлан

ҮЧҮ-2 ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ							
Стратегийн зорилтын нэр, дугаар: 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.11, 3.1.21 эрүүл мэндийн салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар гадаадад гарах мөнгөн урсгалыг бууруулна. Стратегийн зорилтыг хэрэгжүүлснээр гарсан үр дүн: Сүүлийн 4 жилийн хугацаанд эрүүл мэндийн салбар 100 гаруй шинэ эмчилгээ, техник технологи нэвтрүүлж, иргэд олон төрлийн эмнэлгийн тусламж үйлчилгээг эх орондоо авах таатай нөхцөл бүрдлээ. - Улсын нэгдүгээр төв эмнэлэг - донороос шөрмөс суулгах хагалгаа, - Улсын хоёрдугаар төв эмнэлэг - хэт өндөр давтамжит долгионоор түлэх эмчилгээ, - Улсын гуравдугаар эмнэлэг - зүрхний агшилт дэмжигч төхөөрөмж суулгах мэс засал, тархи судасны цүлхэнгийн хагалгаа, - Хавдар судлалын үндэсний төв - элэгний хавдрыг эрт үед нь өндөр долгионоор түлэх эмчилгээ, - Гэмтэл, согог судлалын үндэсний төв - өвдөгний үенд бүтэн үе суулгах мэс засал, - Амгалан амаржих газар - умайн салст давхаргыг өндөр давтамжит радио долгионоор түлэх эмчилгээ, - Цус сэлбэлт, судлалын үндэсний төв - цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах үйл ажиллагаанд 15 шинэ технологи нэвтрүүлж, цусны нөөцийг 5,5 дахин нэмэгдүүлж чанарын баталгаа, аюулгүй байдлын ISO стандартыг хангасан.							
1.	Үр дүнгийн шагуур үзүүлэлт №1 Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах мэс засал	Мэс засал хийлгэсэн хүний тоо	2	2	7	5	
2.	Үр дүнгийн шагуур үзүүлэлт №2 Элэг шилжүүлэн суулгах мэс засал	Мэс засал хийлгэсэн хүний тоо	10	9	30	37	33

3.	Үр дүнгийн шагуур үзүүлэлт №3 Бөөр шилжүүлэн суулгах мэс засал	Мэс засал хийлгэсэн хүний тоо	20	19	25	26	29
----	--	-------------------------------	----	----	----	----	----

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны жилийн эцсийн тайлан

ҮЧУ-2 НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ:

